



**БИЧИЛ УУРХАЙН**

Мэдлэгийн төв

## Мэдлэгийн Төвийн Удирдах зөвлөл

Бичил уурхайн Мэдлэгийн төвийн Удирдах зөвлөл нь Мэдлэгийн төвийг олон нийтэд төлөөлөх бөгөөд үүний тогтвортой хэрэгжилтийг баталгаажуулах удирдлага зөвлөмжөөр хангах, стратегийн чиглэл өгөх үүрэгтэй.

Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл, үүрэг хариуцлага:

- Мэдлэгийн төвийн стратегийн төлөвлөлт, бизнесийн үйл ажиллагааг тодорхойлох
- Мэдлэгийн төвийн Ажлын албаны үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг чиглэл өгөх
- Мэдлэгийн төвийн үйл ажиллагааг бүхэлд нь хянаж мониторинг хийх
- Мэдлэгийн төвийн үйл ажиллагаанд чанар болон хариуцлагыг баталгаажуулах

Удирдах зөвлөл хоёр жил тутам сонгогдон ажиллана. Зөвлөлийн гишүүд бичил уурхайн сэдэвчилсэн бүлгүүдийг ахалж удирдана. Сайн дурын үндсэн дээр ажиллах гишүүд нь мэдлэгийн төвийн үйл ажиллагаанд хяналт тавих, батлах мэдлэг, чадвартай байна.

Шаардлагатай тохиолдолд Удирдах зөвлөлийн гишүүд мэдлэгийн төвийн тогтвортой байдлыг бий болгоход санхүүжилт хөрөнгө босгох үүрэгтэй байна. Удирдах зөвлөлийн хурлыг улиралд 1 удаа зохион байгуулах бөгөөд мэдлэгийн төвийн бодлого, зорилго, санхүүгийн зарцуулалтыг хянах, жилийн ажлын төлөвлөгөө, санхүүгийн хуваарилалт, үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ гэх асуудлаар ярилцаж удирдлагаар хангаж ажиллана.

### Удирдах зөвлөлийн гишүүд

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
2. Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо
3. Байгаль орчин, аялал жуулчлалын яам
4. Ашигт малтмал газрын тосны газар
5. Монголбанк
6. Хүний эрхийн Үндэсний комисс
7. Хөгжлийн шийдэл ТББ
8. МЕРИТ төсөл
9. Швейцарын хөгжлийн агентлаг/Тогтвортой бичил уурхай төсөл\*

### Сэдэвчилсэн бүлгүүд

Мэдлэгийн төв нь дөрвөн үндсэн сэдвээр бүлэг байгуулан ажиллана. Сэдэвчилсэн бүлгүүд нь Мэдлэгийн төвд нийтлэх материал бэлтгэх, мэдээ мэдээлэл цуглуулах ажилд дэмжлэг үзүүлэн ажиллана. Сэдэвчилсэн бүлэг бүр дотроо бичил уурхайтай холбоотой дэд сэдэвтэй байна. Тухайн сэдвүүдийг тухайн чиглэлээр туршлагатай, мэдлэгтэй, сонирхолтой хүмүүс удирдана. Сэдэвчилсэн бүлгийн ахлагч нар Удирдах зөвлөлийн

\* 2019 хүртэл

гишүүн байна.

- Бичил уурхайн хууль эрх зүйн орчин (УУХҮЯ удирдана)
  - Газрын асуудал, ашигт малтмалын эрх
  - Үндэсний гео-датад нэвтрэх
  - Үндэсний түвшний болон орон нутгийн удирдлагуудтай хамтран ажиллах
  - Хууль тогтоомж, бодлого боловсруулах
  - Уул уурхайн компаниуд ба бичил уурхайчдын байгууллагын хамтын ажиллагаа
- Хүний эрхэд сууринсан хандлага ба албажуулалт (МБҮНДХ удирдана)
  - Хүний эрх ба жендерийн тэгш байдал,
  - Бичил уурхайчдын зохион байгуулалт, албажуулалт
  - Бичил уурхайчдын оролцоо болон чадавхжуулах
  - Мэргэшүүлэх болон хөдөлмөр эрхлэлтийг төрөлжүүлэх
  - Орон нутаг болон бичил уурхайчидтай ажилладаг хамтрагчдыг чадавхжуулах
- Эдийн засгийн тогтвортой байдал, нийлүүлэлтийн сүлжээ (Монголбанк удирдана)
  - Бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээгээр эдийн засгийг бэхжүүлэх
  - Хариуцлагатай уухайн санаачилга Шударга олборлолт болон ОЕДС-ийн удирдамж
  - Орон нутгийн эдийн засгийн хөгжил
  - Урт хугацааны, найдвартай бизнес эрхлэх боломж
  - Эдийн засгийн төрөлжилт ба бүтээмж
- Байгаль орчин, аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд (БОАЖЯ удирдана)
  - Мөнгөн усгүй технологи таниулах, шинэ технологи нэвтрүүлэх
  - Байгаль орчныг хамгаалах (төлөвлөлт, нөхөн сэргээлт ба хяналт)
  - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй